



**ДОРНОГОВЬ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим худас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2023. 04. 20 № 1-6/410

танай -ны № -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорноговь аймгийн аймгийн ТЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийллээ.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн орлого 76,723.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оноос 41,111.7 сая төгрөгөөс өссөн байна. Энэ нь Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор зарим татварын орлого орон нутагт төвлөрдөг болсонтой холбоотой байна.

Тайлант онд сургууль, цэцэрлэг, сумдын эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж, харьяа яамандаа нэгтгэгдсэнээр нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгөөс 131,532.2 сая төгрөгийн хөрөнгө шилжсэн байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд Засаг даргын бусад ангилагдаагүй нөөц хөрөнгийн зардлаас ИТХ-аар батлаагүй зардал болох Дорноговь Орон сууц ОНӨААТҮГ-т цалингийн зардалд 8.3 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 68.1." Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална" гэж заасныг зөрчсөн байна.

"Сайншанд суманд 640 хүүхдийн сургуулийн гадна, дотор инженерийн шугам, сүлжээ, гадна тохижилт, гадна дотор цахилгаан хангамжийн ажил"-ын захиалагчийн хяналтын зардал болох 47.8 сая төгрөгийг аймгийн ИТХ-аар батлуулалгүй өөр ажлын санхүүжилтээс олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл

010020033

ажиллагааны журмын З дугаар зүйлийн 3.2.1-т “ажлын хэсгийн боловсруулсан тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг санал тус бүрээр хэлэлцэн батлах, нийтэд мэдээлэх”, гэж заасныг зөрчсөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ анgid эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ





## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны  
санхүүгийн нэгтгэсэн тайландаа хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг 2023 он	Аудитын менежер: Утас: 70523020	У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Аудитор: Аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn
		Б.Алтанзул Цахим хаяг: altanzui.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ..
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрыйн аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн замчилж аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НБББ	Нягтлан бодох бүртгэлийн боллогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СИТХ	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



**ДОРНОГОВЬ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2023. 04. 20 № 1-б/И10

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорноговь аймгийн аймгийн ТЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийллээ.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд орон нутгийн орлого 76,723.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оноос 41,111.7 сая төгрөгөөс ессен байна. Энэ нь Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор зарим татварын орлого орон нутагт төвлөрдөг болсонтой холбоотой байна.

Тайлант онд сургууль, цэцэрлэг, сумдын эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж, харьяа яамандаа нэгтгэгдсэнээр нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгөөс 131,532.2 сая төгрөгийн хөрөнгө шилжсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд Засаг даргын бусад ангилагдаагүй нөөц хөрөнгийн зардлаас ИТХ-аар батлаагүй зардал болох Дорноговь Орон сууц ОНӨААТҮГ-т цалингийн зардалд 8.3 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 68.1." Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална" гэж заасныг зөрчсөн байна.

"Сайншанд суманд 640 хүүхдийн сургуулийн гадна, дотор инженерийн шугам, сүлжээ, гадна тохижилт, гадна дотор цахилгаан хангамжийн ажил"-ын захиалагчийн хяналтын зардал болох 47.8 сая төгрөгийг аймгийн ИТХ-аар батлуулалгүй өөр ажлын санхүүжилтээс олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл

010020033

ажиллагааны журмын З дугаар зүйлийн 3.2.1-т “ажлын хэсгийн боловсруулсан тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг санал тус бүрээр хэлэлцэн батлах, нийтэд мэдээлэх”, гэж заасныг зерчсөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хурээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бурийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,249,715.9	37,438,091.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,086,193.4	21,259,063.9
33	АВЛАГА	9,372,573.2	4,662,075.9
34	УРЬДЧИЛГАА	1,170,514.1	5,324,688.9
35	БАРАА МАТЕРИАЛ	11,560,126.1	6,127,712.7
36	НӨӨЦИЙН БАРАА	60,309.1	64,549.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	213,182,701.5	121,089,781.3
37	ҮРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4,452,341.0	8,306,414.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	208,730,360.5	112,783,366.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	244,432,417.5	158,527,872.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,112,420.2	33,060,786.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,230,158.2	8,540,420.2
42	ҮРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,882,262.0	24,520,366.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	221,319,997.3	125,467,086.3
51	Засгийн газрын хувь оролцоо	221,319,997.3	125,467,086.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	244,432,417.5	158,527,872.5

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	135,296,824.6	130,941,647.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	32,666,318.1	74,194,213.8
110	Орлогын албан татвар	20,040,959.1	35,077,820.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,671,517.1	33,295,069.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,958,989.4	23,452,364.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	113,408,413.2	101,858,627.3
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	113,408,413.2	101,858,627.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,578,135.5	92,394,197.2
211	XYY	0.0	946,300.0
212	ТАТААС	327,620.7	50,000.0
213	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,502,657.0	8,468,130.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	21,888,411.4	29,083,019.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	7,490.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,330,156.9	122,875,837.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	18,558,254.6	-93,785,327.6

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,415,918.4	47,768,699.5	77,736,528.5	203,921,146.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	671,513.7	213,726.9	2,852,341.1	3,737,581.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	79,087,432.1	47,982,426.4	80,588,869.7	207,658,728.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	-4,652,173.0	0.0	-4,652,173.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	498,345.0	-20,360.5	0.0	477,984.5
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	56.0	0.0	0.0	56.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	64,718.8	-787,571.8	0.0	-722,853.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	18,558,254.6	18,558,254.6
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,650,551.9	42,522,321.1	99,147,124.2	221,319,997.3
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	79,650,551.9	42,522,321.1	99,147,124.2	221,319,997.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-35,655,533.5	-22,587,060.9	-8,532,614.6	-66,775,209.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,995,018.4	19,935,260.3	90,614,883.2	154,545,161.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,118,971.8	-2,279,962.9	-4,699,390.9	-8,098,325.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-230,791.6	-265,083.1	-988,076.0	-1,483,950.7
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	-159,758.0	0.0	158,758.0	-1,000.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	9,091.0	-342,948.3	-93,785,327.6	-94,119,184.9
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	42,494,588.0	17,047,265.9	65,925,232.4	125,467,086.3

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	127,952,160.1	146,856,960.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	32,667,914.1	74,194,213.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,096,644.8	47,315,555.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,187,601.1	25,347,191.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,988,434.3	88,081,784.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,988,434.3	88,081,784.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,036,293.1	65,294,128.9
211	XYY	0.0	946,300.0
212	ТАТААС	327,620.7	50,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,624,520.5	21,791,355.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	34,963,725.8	58,775,176.2
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	486.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	35,035,640.8	45,593,232.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,035,640.8	45,593,232.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-35,035,154.8	-45,593,232.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	230,835.1	-1,009,073.0
14	Бусад эх үүсвэр	1,238,617.9	38,108.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,007,782.8	1,047,181.3
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	159,406.1	12,172,870.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,926,787.3	9,086,193.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,086,193.4	21,259,063.9

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Ко д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	130,408,724.4	86,074,360.8	44,334,363.6	66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,915,027.2	53,435,870.4	19,479,156.8	73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,563,703.9	31,249,454.7	5,314,249.2	85
211	XYY	1,683,685.5	946,300.0	737,385.5	56
212	ТАТААС	50,000.0	50,000.0	0.0	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,617,637.8	21,190,115.8	13,427,522.0	61
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	57,493,697.2	32,638,490.4	24,855,206.8	57
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	130,408,724.4	91,858,339.6	38,550,384.8	70
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,382,545.5	17,322,278.4	60,267.1	100
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	107,042,134.8	72,625,432.2	34,416,702.6	68
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,984,044.1	1,910,629.0	4,073,415.1	32
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	6,462,392.2	-6,462,392.2	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	12,246,370.9	12,246,370.9	0

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,066.0	1,648.0	1,418.0	54
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	104.0	104.0	0.0	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,481.0	772.0	709.0	52

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	10,007,027.8	10,007,027.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	9,694,527.6	-9,694,527.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	8,871,726.3	-8,871,726.3
211	XYY	-	0.0	0.0
212	ТАААС	-	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	822,801.3	-822,801.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	312,500.2	-312,500.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	0.0	0.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	9,947,188.5	-9,947,188.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,947,188.5	-9,947,188.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-59,839.4	59,839.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	59,839.4	-59,839.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.0	0.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дорноговь аймаг “Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, иргэн бүр нь тогтвортой хөгжлийн боловсролтой, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, амьжиргааны тувшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвараар тэргүүлэгч аймаг болно” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хангахад дараах стратегийн зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд,

- Байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, орчны бохирдол, доройтлыг бууруулна.
- Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурал, нийгмийн эмзэг байдлыг бууруулж, амьжиргааны түшинг дээшлүүлнэ.
- Иргэн бүрийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлж, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, хариуцлагатай уул уурхай, тогтвортой хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Хууль ёсыг эрхэмлэсэн, иргэдэд хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоог бүх шатанд хангасан нэгдмэл бодлоготой сайн засаглалыг бэхжүүлнэ.

Тайлант 2022 оныг “Хүүхдэд ээлтэй орон нутаг” болгон зарласан байна. Уг зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажилласан байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг Засаг захиргаа, орон нутаг нь эрхэмлэн хүндэтгэж, хүүхдэд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх
- Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхэд бүр нийгмийн суурь тусламжийг хүртэх, эрүүл аюулгүй эсэн мэнд амьдрах, сурч, хөгжих таатай орчныг бүрдүүлэх
- Хүүхэд эрүүл аюулгүй таатай цэвэр орчинд амьдрах хүүхдэд ээлтэй орчин нэхцэлийг сайжруулах
- Хүүхэд бүр гэр бүлдээ аз жаргалтай байх, зөв хүнийг бэлтгэхэд гэр бүлд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх
- Боловсролын орчин дахь хүүхдийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, эрүүл хооллох дадалд суралцахад нөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэх

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь:

- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, аймгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран

- зарцуулах санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
  - Аймгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авах чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас төсвийн 38 байгууллага, төрийн өмчийн оролцоотой 2 аж ахуйн нэгж, байгууллага, орон нутгийн өмчийн оролцоотой 5 аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшлийн 1 байгууллага, 10 тусгай сангийн нийт 56 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдсэнээс төлөвлөгөөт хяналт шалгалтыг 44 байгууллага, аж ахуйн нэгжид, удирдах дээд шатны шийдвэрээр 9, төлөвлөгөөт бус 3 байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Шалгалтаар 624.8 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, 548.2 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсвийн орлого болгохоор, 75.6 сая төгрөгийг данс бүртгэлд тусгуулахаар улсын ахлах байцаагчийн 207 акт тогтоож, зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 19 албан шаардлага бичсэн байна.

Тайлант хугацаанд 128.5 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлж, 68.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлангын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлангын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн ТЕЗ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/646 дугаар аймгийн Засаг даргын захирагчаар батлуулсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 85,904.5 сая төгрөгөөр буюу 64.8 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний улдэгдэл	Эцсийн улдэгдэл	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,086.2	21,259.1	12,172.9
Авлага	9,372.6	4,662.1	(4,710.5)
Урьдчилгаа	1,170.5	5,324.7	4,154.2
Бараа материал	11,560.1	6,127.7	(5,432.4)
Нөөцийн бараа	60.3	64.5	4.2
Урт хугацаат хөрөнгө оруулалт	4,452.2	8,306.4	3,854.2
Үндсэн хөрөнгө	208,730.4	112,783.4	(95,947.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>244,432.3</b>	<b>158,527.9</b>	<b>(85,904.4)</b>
Өр төлбөр	23,112.4	33,060.8	9,948.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	221,320.0	125,467.1	(95,852.9)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>244,432.4</b>	<b>158,527.9</b>	<b>(85,904.5)</b>

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгийн дүн 85,904.5 сая төгрөгөөр буурсан нь ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сумдын эрүүл мэндийн төв, соёлын төвүүд улсын төсвийн байгууллага болж харьяа яамандаа нэгтгэгдэг болсноор орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэл тайлангийн үзүүлэлтүүд буурахад нөлөөлсөн байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 21,259.1 сая төгрөг болж, өмнөх оноос 12,172.9 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний улдэгдэл	Эцсийн улдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	26.8	1.8	(25.0)
Банканд байгаа бэлэн мөнгө	9,059.4	21,257.3	12,197.9
Төгрөг	9,059.4	21,257.3	12,197.9
Төрийн сангийн харилцах	8,384.5	19,924.7	11,540.2
Арилжааны банк дахь харилцах	615.1	1,332.6	717.5
Нэмэлт дансны харилцах	59.8	-	(59.8)
<b>Дүн</b>	<b>9,086.2</b>	<b>21,259.1</b>	<b>12,172.9</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж харьяа яаманд шилжсэнээр мөнгөн хөрөнгө нийт дүн 423.9 сая төгрөгөөр буурсан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд: Орон нутгийн хөгжлийн санд 9,817.5 сая төгрөг, засгийн газрын тусгай сангуудад 2,434.2 сая төгрөг, байгууллагуудын ахмадын санд 102.7 сая төгрөг, нэмэлт дансны төвлөрүүлэлт 960.1 сая төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд 2,602.7 сая төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 4,007.5 сая төгрөгийн тус тус төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Арилжааны банканд нийт 11 байгууллагын 1,332.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн санд түрээсийн орон сууцны тендер зарлагдаагүйгээс хэмнэгдсэн 7,828.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан

татварын орлого 200 хувь биелэгдэж орон нутгийн ерөнхий орлого 4,007.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан.

#### Аудитын илрүүлэлт

Мандах сумын ХХС - Тайлант хугацаанд Хоршоо хөгжүүлэх сангийн орлогоос 65.3 сая төгрөгийг сумын ерөнхий орлогод шилжүүлэн зарцуулаад буцаан шилжүүлсэн зөвлөмж хүргүүлэв.

Сайхандулаан сумын ИТХ - Гус байгууллага нь ИТХ-ын нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны А/ЗО дугаар тушаалаар 4 хунд шагналын мөнгө олгохоор бэлнээр гаргаж авсан ч шагналд зарцуулаагүй байсанд төлбөрийн акт тогтоосон.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба - Бэлнээр мөнгөөр орлогын 7.1 сая төгрөг залгасан 7.1 сая төгрөг нийтийн 14.2 сая төгрөгийн гүйлгээг тайлантын оно гүнцэтгэсэн байна. Уг гүйлгээг байгууллагын кассын дансанд тусгахгүйгээр бэлэн бус гүйлгээ мэтээр бүртгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

#### **3.4.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 4,662.0 сая төгрөг болж, өмнөх оноос 4,710.5 сая төгрөгөөр буурсан байна.

#### **Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл**

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+/-) Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	211.5	43.0	(168.5)
Төлбөртэй үйлчилгээний авлага	96.5	1.3	(95.2)
Татаас, санхүүжилтийн авлага	-	0.0	1.9
Зээлийн хүүгийн авлага	102.2	40.6	(61.6)
Дансны авлага /ТӨҮГ/	2,492.2	1,175.6	(1,316.6)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	1.2	2.0	0.7
Байгууллагаас авах авлага	3,534.7	459.6	(3,075.1)
Хувь хумуусээс авах авлага	22.3	25.1	2.8
Зээлийн авлага	2,911.9	2,914.8	2.9
<b>ДҮН</b>	<b>9,372.5</b>	<b>4,662.0</b>	<b>(4,710.5)</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 2,934.9 сая төгрөг нь сумдын ХХС-ийн, 116.7 сая төгрөг нь сумдын ОНХС-ийн, 814.4 сая төгрөг нь нэмэлт дансны, 246.4 сая төгрөг нь улсын төвийн хөрөнгө оруулалтын, 994.0 сая төгрөг нь Чандмань-Илчийн, 295.8 сая төгрөг нь бусад байгууллагын авлагын үлдэгдэл байна. Мөн авлага буурсан нь сургууль, цэцэрлэг, сумдын эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж харьяа яамандаа нэгтгэгддэг болсонтой холбогдуулан авлага буурсан байна.

#### Аудитын илрүүлэлт

Дэлгэрэх сумын ИТХ - Санхүүгийн тайландаа тусгасан 1.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй, эзэн холбогдолгчгүй авлагын асуудлыг шийдвэрлээгүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Өргөн сумын ХХС - Зээл болон зээлийн хүү талдангийн үлдэгдэлтэй 2 зээлдэгчийн 1.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг зээлдэгчтэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 6 зээлдэгчийн авлагын үлдэгдлийг 8.5 сая төгрөгөөр зөрүүлж баталгаажуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Хөөсгөл сумын Засаг даргын тамгын газар - Гэрэл цахилгааны зардалд 0.8 сая төгрөг, тушиг халаалтын зардало 4.6 сая төгрөг, шуудан холбооны зардалд 0.4 сая төгрөг төвээрээ

шатахууны зардалд 2.3 сая төгрөгийг илүү шилжүүлэн нийт 8.2 сая төгрөгийн авлагага уусгэсэн зэрчилд зөвлөмжтэй.

Эрдэнэ сумын ИХСанхүүгийн байдлын тайланда тусгагдсан байгууллагаас авах 1.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүйд албан шаардлага хүргүүлсэн байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 5,324.7 сая төгрөг болж, өмнөх оноос 4,154.2 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	92.3	505.4	413.1
<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>1,078.2</b>	<b>4,819.3</b>	<b>3,741.1</b>
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	542.1	4,811.6	4,269.5
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	535.3	6.9	(528.4)
Цалингийн урьдчилгаа	0.8	0.8	-
<b>Дүн</b>	<b>1,170.5</b>	<b>5,324.7</b>	<b>4,154.2</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 6,127.7 сая төгрөг болж, өмнөх оноос 5,432.4 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Туухий эд материал</b>	<b>2,962.3</b>	<b>1,248.9</b>	<b>(1,713.4)</b>
Тусгай зориулалттай материал	1,994.4	659.9	(1,334.5)
Эм боох материал	967.9	589.0	(378.9)
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>0.1</b>	<b>-</b>	<b>(0.1)</b>
Бэлэн бүтээгдэхүүн	453.0	275.0	(178.0)
<b>Хангамжийн материал</b>	<b>7,958.8</b>	<b>4,414.5</b>	<b>(3,544.3)</b>
Бичиг хэргийн материал	314.7	121.2	(193.5)
Аж ахуйн материал	4,897.5	3,323.9	(1,573.6)
Сэлбэг хэрэгсэл	93.1	104.4	11.3
Тулш, шатах тослох материал	161.3	88.4	(72.9)
Барилгын засварын материал	77.3	1.5	(75.8)
Хунсний материал	204.9	0.8	(204.1)
Бусад хангамжийн материал	2,210.0	774.3	(1,435.7)
<b>Мал амьтад</b>	<b>185.9</b>	<b>189.3</b>	<b>3.4</b>
<b>Дүн</b>	<b>11,560.1</b>	<b>6,127.7</b>	<b>(5,432.4)</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сургууль, цэцэрлэг, сумдын эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж харьяа яамандаа нэгтгэгддэг болсонтой холбогдуулан бараа материал буурсан үзүүлэлттэй байна

Аудитын илрүүлэлт:

**Дэлгэрэх сумын ЗДТГ** – Малын үлдэгдлийг запруулах өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэсгүй тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон нас дэвшилтийн орлогыг бүртгэлд тусгагчийг зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

**Замын-Үүд сумын ЗАА** – Тайлант онд хөрөнгө оруулалтын ажлаар тус сумын Гадаадын црэгэн харьяатын газарт 2022 онд нийт 148.7 сая төгрөгийн Завтомашин худалдан авч өгсөн бөгөөд тус хөрөнгө нь ЗДТГ-ын бусао хангамжийн материалд бүртгэлтэй зөрчилд зөвлөмж өгсөн.

**Замын-Үүд сумын ЗАА** – Тусгай зориулалтын баараа материалын эцсийн үлдэгдлийг шалгахад оуусгаар болсон нийт 272.7 сая төгрөгийн 17 ажлын зураг бүртгэлтэй хэвээр байгаа нь баараа материалын эцсийн үлдээдэл буруу шлэхийлэгдэхээс гадна хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын зургийн үнэ анхны өртөгт шингэхгүй байх эрсдэлтэй зөрчилд зөвлөмж өгсөн.

**Улаанбадрах сумын ЗДТГ** – Тулиш, шатах тослож материал дансандо бүртгэлтэй шатахууны зарцуулалтын тооцооллыг давтан хийхэд 0.2 сая төгрөгийн шатахууныг нэг машин дээр нэг бөөр давхардуулан бичиж зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

**Хатаноулаг сумын ИТХ** – Тайлант оны 9 дүгээр сард зохион байгуулсан сумын заплуучуудын чуулга уулзалтаар 2.2 сая төгрөгийн 130 ширхэг малгай захтай цамцыг худалдан авч уулзалтад оролцсон црэгдээд тарааж өгч, ижилссэн байна. Эдгээр хувцсыг оролцогчдоос буцааж аваагүй байдал жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлд тус хөрөнгийг байгаа мэтээр тусгаж, тооллогын чанаргүй гүйцэтгэсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 10,224.9 сая төгрөг болж, өмнөх оноос 5,772.6 сая төгрөгөөр ессөн байна.

#### Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Урт хугацаат хөрөнгө оруулалт	4,452.3	10,224.9	5,772.6
Дүн	4,452.3	10,224.9	5,772.6

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө буюу урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэлд, Азийн хөгжлийн банкны эргэн төлөгдөх нөхцөлтэй цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтын "OL-3388MON-2" төслийн 9,126.9 сая төгрөг, "OL-2301MON-12" төслийн 900.0 сая төгрөг тус тус үлдэгдэлтэй байна.

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дунгээр 112,783.3 сая төгрөг болж, өмнөх оноос 95,947.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	197,273.9	106,206.2	(91,067.7)
Барилга, байгууламж, орон сууц	138,849.5	48,954.7	(89,894.8)
Авто-тээврийн хэрэгсэл	6,037.9	5,340.8	(697.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	10,145.8	8,401.5	(1,744.3)
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,454.1	1,030.5	(2,423.6)
Зам, гүүрний байгууламж	8,041.9	7,404.7	(637.2)
Түүх соёл, музейн дурсалт зүйлс	756.4	48.7	(707.7)
Бусад үндсэн хөрөнгө	15,951.6	14,784.9	(1,166.7)

Дуусаагүй барилга, байгууламж	13,117.9	20,208.3	<b>7,090.4</b>
Ном	918.8	32.1	<b>(886.7)</b>
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>11,456.5</b>	<b>6,577.1</b>	<b>(4,879.3)</b>
Программ хангамж	146.7	126.9	<b>(19.7)</b>
Бусад биет бус хөрөнгө	11,309.7	6,450.1	<b>(4,859.6)</b>
<b>Дүн</b>	<b>208,730.4</b>	<b>112,783.3</b>	<b>(95,947.1)</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайллан

Тайлант онд нийт 23,048.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд, худалдан авсан 755.8 сая төгрөгөөр, балансаас баланст шилжүүлсэн авсан 711.4 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй болон хандив 21,321.9 сая төгрөгөөр, дахин үнэлгээний нэмэгдэл 259.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Тус онд хөрөнгө худалдан борлуулсан 2,601.6 сая төгрөг, хөрөнгө актапсан 574.9 сая төгрөг, шилжүүлсэн 396.8 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилүүлсэн 131,946.9 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Бүтцийн өөрчлөлтийн шилүүлсэн нь 131,946.9 сая төгрөг нь сургууль, цэцэрлэг, сумдын эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж харьяа яамандаа нэгтгэгддэг болсонтой холбоотой шилүүлэг байна.

Дуусаагүй барилга байгууламжийн дансанд 8,958.5 сая төгрөгийн аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажил, 11,249.8 сая төгрөгийн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажил бүртгэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Өргөн сумын ОНХС – Тус сангийн хөрөнгөөр хийгдэж ашиглалтад хүлээн авсан 348.7 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Сайханбулаан сумын ИТХ – Тус байгууллагын хагас бүтэн жилээр байгууллагын хөрөнгийн тооллогыг хийгээгүй, индсэн хөрөнгийг баталгаажуулаагүй байсанд албан шаардлага хүргүүлсэн.

Хатанбулаг сумын ИТХ – Гашлант оно 1.9 сая төгрөгийн 11 төрлийн 8,48 м²-кэ цонхны хамгаалалтыг тус сумын сургуульд тайлант оны 12 дугаар сард шилжүүлсэн болооч зарлагын баримтыг үйлдээгүйн улмаас ИТХ-ын санхүүгийн тайланд бүртгэгдсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

Эрдэнэ сумын ИТХ – 2021 оны санхүүгийн тайланийн аудитаар өгсөн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлж бүртгэх тухай зөвлөмжийг хэрэгжүүлэсгүйд албан шаардлага хүргүүлсэн байна.

Аймгийн ОНХС - ГХБХБГ-аас 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр "Халдвартын эмнэлэг барих ажил" Халдвартын эмнэлгийн ариутгалын барилга, цэвэрлэх байгууламж барих ажил"-ыг хүлээн авсан боловч Орон нутгийн өмчийн газарт холбогдох материалыг хургуулэсгүйн улмаас ашиглагч байгууллага бүртгэлтусгаагүй зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 35,695.1 сая төгрөг болж, өмнөх оноос 12,582.7 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>5,230.1</b>	<b>8,540.4</b>	<b>3,310.3</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	304.3	8.8	(295.5)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	406.2	10.6	(395.6)
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	235.5	235.5
<b>Бусад өглөг</b>	<b>4,500.9</b>	<b>2,358.9</b>	<b>(2,142.0)</b>

Байгууллагад төлөх өглөг	3,160.8	1,100.5	(2,060.3)
Хувь хүмүүст төлөх өглөг	28.1	26.0	(2.1)
Татварын өглөг /ТӨҮГ/	480.0	219.8	(260.2)
Дансны өглөг /ТӨҮГ/	832.0	1,012.6	180.6
Урьдчилж орсон орлого	18.7	5,926.6	5,907.9
Урт хугацаат өр төлбөр	17,882.3	24,520.4	6,638.1
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	6,330.2	10,224.9	3,894.7
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	11,552.1	14,295.5	2,743.4
<b>ДҮН</b>	<b>23,112.4</b>	<b>33,060.8</b>	<b>9,948.4</b>

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрөөс сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж харьяа яаманд шилжсэнээр 370.8 сая төгрөгийн өр төлбөр хасагдсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Чандмань-Илч ОНӨХХК-д шилжүүлсэн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөвт ажил 14,284.6 сая төгрөг, Дагшин- Эрдэнэ ОНӨХХК-ийн 10.8 сая төгрөг, Азийн хөгжлийн банкны төслийн зээл 10,224.9 сая төгрөгийн урт хугацаат зээл тус тус бүртгэлтэй байна.

<b>Аудитын илрүүлэлт:</b>
Замын-Үүд сумын ЗДТГ – Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлын 100.0 сая төгрөгийг сумын Онцгой комиссын үйл ажиллагаано зориулалт бусаар зарцуулж, өглөг дүсгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн.
Мандах сумын ХХС-Тайлант онд хоёр зээлдэгч зээлийн үлдэгдлийг хаахдаа 0.2 сая төгрөгийг илүү шилжүүлснийг аудитын явцад өглөгт тусган заплуулж, өглөгийг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн байна.
Улаанбадрах сумын ИТХ – Засварын аудитаар 3-р улирлын санхүүгийн тайлангийн өр төлбөрийн үлдэгдэл 7.6 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.
Сайншанд сумын ИТХ - Нийгмийн даатгалын шимтэгэл төлөлтийн тайланг члээхээдээ 2022 оны 5, 7, 8-р саруудад албан хаагчдын хөдөлмөршийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг сарын бодогдсон цалингаас нийт 4.5 сая төгрөгөөр илүү тайлагнаасан байна. Мөн багийн иргэдийн нийтийн хурлын дарга-нарын 2, 3 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал болох 10.0 сая төгрөгийг нийгмийн даатгалын тайланда тайлагнаагүй орхигдуулсано албан шаардлага хүргүүлсэн байна.

#### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 125,467.2 сая төгрөг болж, өмнөх оноос 95,852.8 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	56,106.1	19,295.4	(36,810.7)
Өмч /терийн/ /ТӨҮГ/	23,030.1	22,675.7	(354.4)
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	514.4	523.5	9.1
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>99,147.1</b>	<b>65,925.3</b>	<b>(33,221.9)</b>
Өмнөх үеийн үр дүн	80,588.9	159,710.6	79,121.7
Тайлант үеийн үр дүн	18,558.3	(93,785.3)	(112,343.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,522.3	17,047.3	(25,475.0)
<b>ДҮН</b>	<b>221,320.0</b>	<b>125,467.2</b>	<b>(95,852.8)</b>

## Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо нь сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж харьяа яаманд шилжсэнээр 118,405.3 сая төгрөгөөр буурсан байна.

### Аудитын илрүүлэлт:

Сайншанд сумын Агатова ӨЭМТ - Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх өмчин дунгээс 107.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаад зөвлөмж хүргүүлсэн байна.

Сайншанд сумын Мишээлт мана ӨЭМТ - Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх өмчин дунгээс 69.5 сая төгрөгөөр зөрүүтэй байгаад зөвлөмж хүргүүлээ.

Сайншанд сумын Орх талст ӨЭМТ - Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын өмчийн дүн улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх өмчин дунгээс 26.0 сая төгрөгөөр зөрүүтэй байгаад зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

##### Хүснэгт 10. Төсвийн орлого

/сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлого	18,961.0	20,510.0	1,548.9	108.2
2	Үйл ажиллагааны орлогын татвар	3,594.4	826.8	(2,767.6)	23.0
3	Хадгаламжийн хүүгийн орлого	1,645.9	1,102.7	(543.2)	67.0
4	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	805.8	827.9	22.1	102.7
5	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	718.6	577.6	(141.0)	80.4
6	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(804.9)	(804.9)	0.0	100.0
7	ААН-ийн орлогын албан татвар	6,610.0	12,037.7	5,427.7	182.1
8	Үл хөдлөх хөрөнгийн татвар	1,634.1	1,723.8	89.6	105.5
9	Галт зэвсгийн албан татвар	33.9	27.7	(6.2)	81.6
10	АТБӨЯХ-ийн албан татвар	760.3	1,090.7	330.4	143.5
11	Малын тоо толгойн албан татвар	836.4	676.1	(160.3)	80.8
12	Улсын тэмдэгтийн хураамж	3,334.3	2,818.5	(515.9)	84.5
13	Ан агнах зөвшөөрлийн хураамж	223.1	644.7	421.6	289.0
14	Газрын төлбөр	7,831.2	7,412.6	(418.6)	94.7
15	Рашаан, ус ашигласны төлбөр	599.8	700.7	100.9	116.8
16	Хог хаягдлын хураамж	507.3	332.9	(174.4)	65.6
17	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,793.9	1,238.0	(555.9)	69.0
18	Түрээсийн орлого	30.0	64.0	34.0	213.5
19	Хүүгийн орлого	1,683.7	-	(1,683.7)	-
20	Торгуулийн орлого	2,439.1	1,127.3	(1,311.8)	46.2
21	Нэр зааж ангилагдаагүй орлого	1,373.1	984.4	(388.7)	71.7
22	Төсөвт байгууллагын өөрийн орлого	270.6	295.9	25.3	109.4
23	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	30.0	57.5	27.5	191.6
24	Дуудлага худалдааны орлого	52,401.1	22,450.9	(29,950.2)	42.8

**НИЙТ ОРЛОГЫН ДҮН**

107,312.7

76,723.4

(30,589.3)

71.5

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд татварын болон татварын бус орлогыг 107,312.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс 76,723.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 30,589.3 сая төгрөгөөр дутуу буюу гүйцэтгэл 71.5 хувьтай байна.

### 3.5.2 Төсвийн төлөвлөлт

Тус аймгийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 15,122.6 сая төгрөг, орон нутгийн төсвийн орлогоос 28,622.7 сая төгрөг, нийт зарлагыг 43,745.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 13,110.2 сая төгрөгөөр бууруулж, 30,635.1 сая төгрөгөөр хянасан байна.

### 3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор 44,305.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 33 хөтөлбөр, арга хэмжээг 130,408.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 72,625.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 17,322.3 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 1,910.6 сая төгрөг нийт 91,858.3 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүртгэж, нийт 86,074.4 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 86,074.4 сая төгрөг буюу 66.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг нийт 44,334.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Үүнд:

#### Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/  
/заралдсан  
/хувь/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Заралдсан /хувь/	Биелэлт /хувь/
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	15,717.1	12,967.9	2,749.2	83
2	80102 Туслах үйл ажиллагааны зардал	44.9	38.7	6.2	86
3	80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү	1,569.2	1,547.5	21.7	99
4	80106 Баг, хорооны ЯАЗардал	1,164.3	1,086.3	78.0	93
5	80111 Төрийн емчийн барилгын тогтмол зардал	8,596.5	8,004.0	592.5	93
6	80112 Нийтлэг үйлчилгээ	1,591.0	1,591.0	0.0	100
7	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	87.2	84.9	2.3	97
8	80305 Биеийн тамирын уралдаан, тэмцэл	7.6	7.6	-	100
9	80405 Улаан будай, махны нийлүүлэлт	50.0	50.0	-	100
10	80506 Дээд шатны төсөвт төвлөрүүлэх	6,617.0	6,617.0	-	100
11	80708 Олон нийтийн оролцоонд түшиглэ	49.2	48.9	0.3	99
12	80709 Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгө	97.2	40.8	56.4	42
13	80801 Нөхөн олговор	200.0	101.1	98.9	51
14	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	584.8	392.3	192.5	67
15	80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	166.0	140.7	25.4	85
16	80918 Бусад	57,571.7	32,650.5	24,921.2	57
17	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	1,891.6	1,833.9	57.7	97
18	81103 Эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө	605.6	212.6	393.0	35
19	81104 Бусад ангилагдаагүй нөөц хөрөн	269.8	164.2	105.6	61
20	81410 Засгийн газрын зээл	1,683.7	946.3	737.4	56

21	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхө	1,553.9	968.5	585.4	62
22	81707 Агаарын бохирдлыг бууруулах	300.0	-	300.0	-
23	81820 Сургалтын төлберийн буцалтгүй	8.0	8.0	-	100
24	82201 Гэмт хөргээс урьдчилан сэргийл	355.1	328.0	27.1	92
25	82203 Нийтийн эзэмшилийн гудамж талбай	154.0	143.4	10.6	93
26	82210 Хотын доторх золбин муур, нохой	40.0	40.0	0.0	100
27	82212 Хур хог хаягдал, орчны бохирдл	80.6	77.5	3.1	96
28	82214 Орон нутгийн чанартай автозамын засвар үйлчилгээ	1,372.5	1,169.4	203.0	85
29	82502 Мал эмнэлгийн үйлчилгээ	240.9	210.8	30.1	87
30	82504 Малын халдварт өвчинээс урьдчил	132.7	120.7	12.0	91
31	82801 Улсын их баяр наадам	80.0	79.9	0.1	100
32	83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал	465.0	420.0	45.0	90
33	83406 ОНХС - Бусад	27,061.5	13,982.0	13,079.5	52
<b>Нийт дүн</b>		<b>130,408.7</b>	<b>86,074.4</b>	<b>44,334.4</b>	<b>66</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Аудитын илрүүлэлт:

Алтанширээ сумын ОНХС - Тайлант онд сумын оран нутгийн төсвээс ОНХС-д гүйцэтгэлээр 121.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон. МТТАТ-ыг 2.8 сая төгрөгээр дутуу шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өгсэн.

Даланжаргалан сумын ОНХС - Тайлант онд СИТХ-ын тогтоолоор батлагдаагүй 29.4 сая төгрөгийг АББАДОНКОНСТРАКШН ХХК-д шилжүүлсэнд албан шаардлага хүргүүлсэн.

Даланжаргалан сумын ИТХ - Үндсэн үйл ажиллагаатай холбоогүй гарсан бэлэг дурсгалын дэвтэр, номд 0.4 сая төгрөг, СИТХ-ын 7, 8, 9, 10 болон жилийн эцсийн хуралдааны үйийн цай болон хоолны зардалд 1.5 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн.

Дэлгэрэх сумын ОНХС - Засгийн газрын тогтоолд сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх зардал 5.0 сая төгрөг гэж тусгасан байтал сумын ИТХ-ын тогтоолд тус зардалд 15.0 сая төгрөгийг төлөвлөн гүйцэтгэлээр мөн дунгэрээр зарцуулж 10.0 сая төгрөгээр тогтоосон хэмжээг хэтрүүлсэн. Үг зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Замын-Үүд сумын ЗДТГ - Тайлант оны IV улиралд сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид нийт 1.0 сая төгрөгийн ажлын үр дунгшин урамшууллыг тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Тайлант онд тус шалгагдагч байгууллага нь 10 албан хаагчид нийт 2.6 сая төгрөгийн шилүү цагийн нэмзгээл хөлсийг журамд заасан хэмжээнээс хэтрүүлэн олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Замын-Үүд сумын ОНХС - Сумын ИТХ-ын 2021 оны 05/13-р тогтоолоор 2022 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний төсвийг батлахдаа өмнө оноос шилжиж ирсэн 373.4 сая төгрөгийн үлдээгээлсанхүүжилттэй 5 төсөл арга хэмжээний тайлант онд олгох санхүүжилтийг 548.3 сая төгрөгээр буюу 174.4 сая төгрөгээр илүү баталсан байна. Мөн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдээгээл 142.8 сая төгрөг байтал батлагдсан төсөвтэй урьд оны үлдээгээс санхүүжих хэмжээг 336.8 төгрөгээр буюу 194.0 төгрөгээр илүү баталж, төсвийн тодотголд өөрчлөлт оруулаагүй нийт 368.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Мандах сумын ЗДТГ - Нуухэн жорлон шинэчлэх ажлын гүйцэтгэсгээд гэсээрэйн билэлтийг дүгнэсгүй, гүйцэтгэлийг албан бичгээр ирүүлэсгүй байхад гүйцэтгэсгч компанийн тайлбар хүсэлтийг үндэслэн холбогдох санхүүжилтийг олгосон байгаад зөвлөмж хүргүүлсэн.

Өргөн сумын ИТХ - Төршийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, сонин сэтгүүл захиалсан 1.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Өргөн сүмын ОНХС - Сүмийн ИТХ-аас баталсан 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын жагсаалтад батлагдаагүй үемнөх 2021 онд батлагдсан боловч хэрэгжээгүй ажил 122:2 сая төгрөгийн ажлыг тайлант онд санхүүжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.**

**Улаанбадрах сүмын ИТХ – Сүмийн ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн төсвийг 8.5 сая төгрөгөөр баталж 8.4 сая төгрөгийг зарцуулсан басангийн хөрөнгөөс сүмийн Тэмээчийн холбоо ГҮТББ-д 7.4 сая төгрөгийн дэмжлэг ёгсөн зөрчилд албан шаардлага ёгсөн.**

**Улаанбадрах сүмын ОНХС - Өмнө оноос шилжиж ирсэн "Төрийн албан хаагийн 8 айлын орон сууц барих" төсөл арга хэмжээний тайлант тоны санхүүжилтийг олгохдоо захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтээс 1.0 сая төгрөгийг барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллагад эзрээний дүнгээс илүү шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.**

**Тайлант онд сүмын ИТХ-ын тогтоолоор өмнө оноос шилжиж ирсэн "Төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц барих" төсөл арга хэмжээг санхүүжүүлэх төсөв батлагдаагүй байхад 66.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон зөрчилд албан шаардлага ёгсөн.**

**Хатанбулаг сүмын ЗДТГ – ЗДНХ-ийн зориулалт зарцуулалтын нийтийг журмын 2.1.5 дахь заалтыг зөрчиж тээврийн хэрэгсэл худалдан авахад 9.9 сая төгрөг, ойн арга хэмжээнд 4.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан зөрчилд албан шаардлага ёгсөн.**

**Хатанбулаг сүмын ОНХС – Сүмийн ИТХ-ын тогтоолоор 213.9 сая төгрөгийн малын тоо толгойн АТ бүрдүүлэхээр төлөвлөсөөс 1.16.2 сая төгрөгийн АТ-ыг бурдуулэн орлогын гүйцэтгэл 97.7 сая төгрөгөөр тасарсан зөрчилд зөвлөмж ёгсөн.**

**Эрдэнэ сүмын ЗДТГ Хувийн ААНБ болон Жишигийн ААНБ-ийн нийт 14.1 сая төгрөгийн хандив тусламжийг авсандаа хандив тусламжийг зохих журмын дагуу хүлээж авах талаар албан шаардлага хүргүүллээ.**

**Аимгийн ОНХС – "Халдвартын эмнэлэг барих ажил" "Халдвартын эмнэлгийн ариутгалын барилга, цэвэрлэх байгууламж барих ажил"-үүдүүн улэгдэл ТАХ-ий санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэлийн баримт бичгийг хянан баталгаажуулаагүй. Тухайн ажлыг яаралтай дуусгах чиглэлээр гүйцэтгээчийн гаргасан батламжид үндэслэн улэгдэл санхүүжилт болох 205.0 сая төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага ёгсөн.**

**"Халдвартын эмнэлгийг барих ажил" "Халдвартын эмнэлгийн ариутгалын барилга, цэвэрлэх байгууламж барих ажил"-үүдүүн зураг төсөөт тусгагдаагүй ажил хийгдээгүй, гүйцэтгэлийн тайлант ирүүлээгүй боловч магадалшгүй ажлын зардал болох нийт 45.5 сая төгрөгийг төсөл, арга хэмжээний өртгийн зардал зарцуулсан зөрчилд албан шаардлага ёгсөн.**

**2021 онд ИТХ-ын тодотголоор батлагдсан "Сайншанд суманд 640 хүүхдийн сургуулийн гадна, доторчинженерийн шугам, сүүлчээ, гадна тохижилт, гадна дотор цахилгаан хангамжийн ажил"-ын захиалагчийн хяналтын зардал болох 47.8 сая төгрөгийн 2022 онд ИТХ-аар батлуулалгүү ёөр ажлын санхүүжилтээс олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.**

**Эм зргэлтийн сан ОНӨААТҮГ – Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хуульд заасан бараглаар гүйцэтгээгүй. Мөнгөн хөрөнгө, бараа материалын анхан шатны баримт бурдуулэлт-хангалтгүй олгосон, зөвшөөрсөн хүлээн авсан гарын үсгийн бурдэлгүү тухайлбал бэлэн мөнгөний 17.2 сая төгрөгийн ажил гүйлгээс бүртгэлд тусгасан зөрчилд албан шаардлага ёгсөн.**

**Тайлант хугацааны санхүүгийн тайланд хийгдэж буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хундрэл саад учруулсан зөрчилд албан шаардлага ёгсөн.**

**Чандмань-Илч ОНӨХХК – Тус компани нийт 5 харилцагчаас 12.4 сая төгрөгийн түрээсийн орлого олсноос 3 харилцагчийн гэрээг орон нутгийн өмчийн газраар хянуулаагүй, гэрээ байгуулаагүй 2 харилцагчийн гэрээний хугацааны дууссан, орлогыг орон нутгийн төсвийн одансанд төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.**

**Худалдан авалтын төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй батлуулаагүй, ТБОНӨБАУХА тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй сэлбээг, материал, бараатажил үйлчилгээг 24 компани, 13 иргэнтэй 5.539.6 сая төгрөгийн шууд худалдан авалтыг хийсэн зөрчилд албан шаардлага ёгсөн.**

НББ-д ашиглагдаж байгаа “Виница” программ нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй таж-ахуйн нээж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага хангагүй, журнал, мэдээллийг албаатай илэрхийлж байгаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Нэг харилцагчтай хийгдсэн 1,689.7 сая төгрөгийн гадаад валютаар бүртгэгдсэн авлагыг цуглуулсан үед 32.4 сая төгрөгийн валютын ханшийн өөрчлөлтийн бодит гарзыг, тайлант хугацааны эцэст 8.4 сая төгрөгийн ханшийн өөрчлөлтийн бодит бусад шийг бүртгээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

НИК-ХХК-Дорноговь салбартай байгуулсан “Шатахууны картын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний 2.6 дахь “Картаар үйлчилгэч нь карт эзэмшигчид, картаар үйлчилгэгчийн мөрөж буй үнийн 3%-н хөнгөлөлтийг гэрээнд заасны дагуу үзүүлнэ гэсэн заалтаар хөнгөлөлтийг эдлэдэг бөгөөд уг хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, зарцуулалтыг нь тайлагнаагүй зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 6,801.3 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,206.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,939.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: цалин хөлс 257.2 сая төгрөг, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл 17.6 сая төгрөг, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 7.9 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 580.2 сая төгрөг, нормативт зардал 776.4 сая төгрөг, эд хогшил, ургал засварын зардал 53.7 сая төгрөг, томилолт 1,139.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 5,719.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 320.1 сая төгрөг, ургал шилжүүлэг 35.8 сая төгрөг, хөрөнгийн зардал 312.5 сая төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 784.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Дорноговь аймгийн ЗДТГ - Тайлант онд 103 сая төгрөгийн нийтлэг үйлчилгээний газраар гүйцэтгүүлсэн цэвэрлэгээ үйлчилгээний хөлсийг нормын хувцас, зөвлөн эдлэлийн зардлаас зориулат бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

Байгууллагаас албан хаягчдад олгосон 5.8 сая төгрөгийн ХЧТАТ-ээс 0.6 сая төгрөгийн ХХОАТ суутгалыг суутгасан зөрчилд зөвлөмж өгсөн.

Тайлант онд 1,336.4 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 13 дэд хөтөлбөрийн хүрээнд 80 зорилтыг дэвшүүлж 300 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

No.	Хөтөлбөр /дэд хөтөлбөр/ хугацаа:	Хэрэгжи хугацаа:	Хүрэх үр дүн	Хэрэ гжил тийн явл	Зарцуу лах тесөв	Зарц уул сан:
1	“Осол гэмтлээс сэргийлэх”	2020-2024	Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлнэ.	94%	3.0	3.0
2	“Гэр бүлийн хүчирхийлэл,	2019-2023	Гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлж, бат бөх тогтвортой хамтын амьдрал, хариуцлагатай гэр	98%	10.4	10.4

	хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”		бүлийг дэмжиж, гэр булийн боловсролыг бүх шатанд олгох сургалтыг тасралтгүй хүргэн эцэг эхчүүдийн хүүхдэдээ тавих хараа хяналтыг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.			
3	“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”	2019-2023	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орчин нөхцөлийг бүрдүүлж, тусlamж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулан, нөлөөллийн болон сургалт, сурталчилгааны ажлаар дамжуулан иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ.	96%	10.4	5.1
4	Бүх нийтийн үндэсний хөтөлбөр	2018-2023	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог сайжруулан хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх, иргэдийн эрх зүйн ухамсыг дээшлүүлнэ.	100%	11.3	11.3
5	“Соёлын биет бус өвийг хамгаалах”	2019-2023	Соёлын биет бус өв ёвлөн уламжлагчдыг олж илрүүлэх, бүртгэх, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэн ажилласнаар ёвлөн уламжлагчдын тоо өмнөх оноос 13,5 хувиар өсөж, 478 болсон үр дүн гарсан.	98%	150.0	125.0
6	“Эрүүл шүүд - Эрүүл хүүхэд”	2019-2023	5 сумдын ЕБС-ын сурагчадад үзлэг зохион байгуулах	95%	29.3	29.3
7	“Англи хэлтэй Дорноговь” зорилтот хөтөлбөр	2021-2025	Англи хэлний сургалтын байгууллагын тоо өмнөх оноос 2-оор нэмэгдэж 6 болсон ба англи хэлний сургалтын хөтөлбөрт 3346 иргэнийг хамруулсан нь суралцагчдын тоо өмнөх оноос 23%-аар өссөн үр дүнтэй байна.	89%	50.0	20.0
8	“Хүүхдэд зэлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөр	2021-2025	хүүхэд эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтвортой үр дүнд хүрэх	93%	140.5	131.1
9	“Иргэн бүр санаачлагч – Эрх бүр үйлдвэрлэгч”	2019-2022	Орон нутгийн түүхийн эдийн нөөц, боломжид тулгуурлан өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн тогтвортой хөгжлийг дэмжих замаар бүтээмжийг өсгөх, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэн импортыг орлох экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх.	94%	-	-
10	“Монгол малчин” дэд хөтөлбөр	2020-2024	Малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмж, орлого, ашгийг нь өсгөх, тэдгээрийг чадавхжуулах	89%	4.2	4.2
11	“Жимс, жимсгэнэ”	2018-2022	Жимс, жимсгэний дотоодын хэрэгцээний хангамж, жимс, жимсгэний мод тариалдаг өрхийн тоог нэмэгдүүлэн үр жимст жимсгэний тоог нэмэгдүүлж жимс, жимсгэнэ, тарвасаар хийсэн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	84%	-	0.5
12	“Хүнсний ногоо”	2018-2022	Хүнсний ногооны нэр төрөл, орон нутгийн хүн амын хүнсний ногооны хангамж, хамгаалагдсан хөрсний тариалалт, хүнсний ногоог дахин боловсруулж, үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнийг тус тус нэмэгдүүлнэ.	90%	0.7	0.7

13	“Тэрбум мод” зорилтот хөтөлбөр	2021-2025	1. Ногоон байгууламжийн хэмжээ - 400,000 ширхэг мод тарьсан байна. 2. Мод тарьж ургуулсан өрхийн тоо-300 аж ахуй нэгж, байгууллагын тоо-20 3. Шинээр байгуулсан мод үргүүлгийн талбайн тоо-2 4. Ойн сангийн талбайн хэмжээ - 1 га	92%	47.5	43.5
	Нийт дундаж			92.8	481.4	405.0

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланда аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлاغналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зөрчил давтан гаргахгүй байх талаар албан шаардлагуудыг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Дэмбэрэлсүрэн, аудитор Б.Алтанзул нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор О.Нарангарав, аудитын менежер У.Оюунтулхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 02/342 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгө сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 2,470.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,705.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг үзүүлэлтүүдээр сонгон 150,509.5 сая төгрөгөөс 1.5 хувиар 2,257.6 сая төгрөгөөр тогтоон материаллаг байдлын 80 хувиар буюу 1,806.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг дахин шинэчлэх болсон нь сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд улсын төсвийн байгууллага болж харьяа яаманд шилжсэнээр балансад нөлөө бүхий өөрчлөлтүүдийг орсноор шинэчлэн тогтоох шаардлагатай болсон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн ТЕЗ-ын харьяа байгууллагуудад байгууллага тус бүр дээрээ холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Арга хэмжээнээс дурдвал Хэмнэлтийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт заасан Аймгийн Засаг дарга нэгзээс илүү орлогч даргатай байхыг хориглох, аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглох, эрх бүхий

этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглосон заалтууд болон хэмнэлтийн бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-ын харьяа ТШЗ-ын байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 42.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 29.1 сая төгрөгийн 13 зөвлөмж, 12.4 сая төгрөгийг 8 албан шаардлага хүргүүлж, 1.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон байна.

Зөвшөөрөгдсөн албан тушаалтнаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашигласан, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, дүрэмт хувцас худалдан авсан, зүйл ажиллагааны тайланг танилцуулсан сонин хэвлэл хэвлүүлсэн, хуульд заагаагүй тэтгэмж олгосон гэх мэт зөрчлүүд илэрч холбогдох байгууллагуудад аудитын шийдвэрүүдийг хүргүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

**Дэлгэрэх сумын ЗДТГ:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтыг зөрчиж, танхимаар сургалт зохион байгуулах зардалд 0.7 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

**Дэлгэрэх сумын ИТХ:** Тус байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтыг зөрчиж, ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 0.5 сая төгрөгийн дэмжлэг узуулсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Тус байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, хэвлэл захиалах зардалд 0.1 сая төгрөг, сургалт, тэмцээн уралдааны зардалд 3.4 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Эрдэнэ сумын ИТХ:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3 дахь заалтыг зөрчин Монголын нутгийн өөрөө удирдах байгууллага шинэчлэн байгуулагдсаны 30 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой үндсэн данснаас сургалт, алдын булан байгуулахад 3.2 сая төгрөг, нэмэлтийн данснаас бэлэг дурсгалын зүйлс авах сургатад 3.3 сая төгрөг шатахууны зардлын төсвөөс 0.1 сая төгрөг, нийт 6.6 сая төгрөгийг зарцуулсан албан шаардлага хүргүүлсэн байна.

**Дэлгэрэх сумын ИТХ:** Тус байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, хэвлэл захиалах зардалд 0.1 сая төгрөг, сургалт, тэмцээн уралдааны зардалд 3.4 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Өргөн сумын ЗДТГ:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг зөрчиж, 1.8 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлсийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, хуульд заагдаагүй шагнал, урамшуулал, тусламжийг албан хаагчдад олгосон 15.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

**Өргөн сумын ИТХ:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, сонин сэргүүл зажиалсан 1.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Өргөн сумын ЗДТГ:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг зөрчиж, 1.8 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлсийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, хуульд заагдаагүй шагнал, урамшуулал, тусламжийг албан хаагчдад олгосон 15.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

**Улаанбадрах сумын ИТХ:** Төрийн хэмнэлтийн тухай хуульд хориглосон ГХУСЗ-аас нийт 1.1 сая төгрөгийг зарцуулж, жилийн эзэст 2.3 сая төгрөгийн шатахууныг худалдан авч үлдэгдлээр тайлагнасан зөрчилд зөвлөмж өгсөн.

**Улаанбадрах сумын ЗДТГ:** Төсвийн хөрөнгөөр нийт албан хаагчдадаа шинэ жилийн баярыг тохиолдуулан 2.1 сая төгрөгөөр бялуу оргилуун дарс авч өгсөн зөрчилд албан шаардлага өгсөн.

**Сайншанд сумын ЗДТГ - Төсвийн хөрөнгөөр БТСГ-тай 2022 оны 9 сараас 4 сарын хугацаатай заалт ашиглах гэрээний байгуулан заалны түрээсийн төлбөрт 0.8 сая төгрөгийг төлсөн, төрийн байгууллагын үйл ажиллагааны тайланг хэвлүүлж 1.5 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Мөн шаардлагагүйгээр их хэмжэээр бараа, материал бэлтгэх, нөөцөлсөн байна. Тухайлбал, Биччин цаас 1.7 сая төгрөгийн 96 бодол, принтерийн хор 1.3 сая төгрөгийн 27ш, 1.5 сая төгрөгийн 3000ш сонин, 4.4 мянган төгрөгийн шатахууныг тус тус нөөцлөн авсан. Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй албан шаардлага хүргүүлсэн байна.**

**Чандмань-Илч ОНӨХХК - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн элгээдээ дараах зүйлсийг хориглоно. 15.1.7 байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах," заалтыг зөрчин 1.0 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсанд төлбөрийн акт тогтоов.**

**Тайлант онд байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс, шагнал, урамшуулалт олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн "15.1.3 хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж шагнал, урамшуулалт, дэмжлэг олгох;," "15.1.5 төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах," заалтуудтай нийцээгүй зөрчилд албан шаардлага ёгсэн.**

**Аяраг сумын ЗДТГ - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.1 "гар утасны зардал" 12.1.3 "хэвлэлийн захиалгын төлбөр"; 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах," заалтуудыг зөрчин 1.5 сая төгрөгийн зардолыг санхүүжүүлсэн зөрчилд зөвлөмж ёгсэн.**

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтооюур баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл оруулсан, хугацаа хоцроосон 2 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Нийт засаг даргын 476 захирамж, 138 төсөл арга хэмжээний 51.1 сая төгрөгийн гүйцэтгэл, 79 тендерийг мэдээлсэн байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн тувшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрыйн аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрыйн аудитын талаар**

Завсрыйн аудитаар ТЕЗ-ийн санхүүгийн тайланд 6 горим сорил хэрэгжүүлж төлөвлөгөөг батлуулсан.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	122.6	1	92.6	75.5
Зөвлөмж	3	-	3	-	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>122.6</b>	<b>4</b>	<b>92.6</b>	<b>87.7</b>

Дорноговь аймгийн Монгол шуудан банкинд 2007 онд "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих" зээлийн чиглэлээр орон нутгийн төсвөөс ААНБ-аас тесөл шалгаруулаад олгох зориулалтаар 60.0 сая төгрөгийн зээл олгож тайланц авлагаар тусгасан боловч, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон байсан. Тус авлагаас төрийн банкны 281500346241 дансанд төслийн олгогдоогүй үлдэгдэл байсныг тодруулж орон нутгийн дансанд төвлөрүүлсэн. Найдваргүй авлагын үлдэгдэл 30.0 сая төгрөг нь 2007 онд үүссэн Монгол шуудан банканд байрлаж байсан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн үлдэгдэл бөгөөд эзэн холбогдогч тодорхойгүй авлага байна. ТЕЗ-аас банкны бүх үлдэгдлийг шүүлгүүлсэн бөгөөд хамаарах арга хэмжээг авч ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн барьцаа хөрөнгийн дансны гүйцэтгэл болон үлдэгдлийг барьцаа байршуулсан тесөл, арга хэмжээтэй тулгах.

Мөн үйл ажиллагаа явуулахгүй байгаа Говь консалтинг менежмент, Дорноговь байгалийн баялаг, Их хөгжлийн гарц орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласныг шалгах

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 44 төсвийн байгууллага, 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 30 тусгай сан, 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан, нийт 99 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 99 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 46 байгууллагыг түүвэрт хамруулж, 53 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: "Өөрчлөлтгүй 38, "Хязгаарлалттай" 11, "Сөрөг" 2 / Сайншанд сумын ЗДТГ, Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ/, "Татгалзсан" 1 дүгнэлт / Замын-Үүд сумын НААҮ ОНӨХХК/ авсан байна.

Аудитаар нийт 17,638.9 сая төгрөгийн 402 алдаа, зөрчил илрүүлснээс 14,508.3 сая төгрөгийн 174 алдааг запруулж, 99.4 сая төгрөгийн зөрчилд 33 төлбөрийн акт тогтоож, 2,900.7 сая төгрөгийн зөрчилд 91 албан шаардлага, 130.6 сая төгрөгийн зөрчилд 104 зөвлөмж өглөө.

#### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 105.3 сая төгрөгийн 15 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 94.1 сая төгрөгийн 7 алдааг запруулж, 2 албан шаардлага өгч, 11.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө. 10 төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчилгүй, 4 төсвийн төвлөрүүлэн захирагчид хязгаарлалттай /Замын-Үүд сум, Өргөн сум, Улаанбадрах сум, Хөвсгөл сум/ дүгнэлт өгсөн.

#### Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 74 байгууллагаас 42 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, зөрчилгүй 25, хязгаарлалттай 6, сөрөг 1 /Сайншанд сумын ЗДТГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15,613.0 сая төгрөгийн 335 алдаа, зөрчил илрүүлснээс 14,903.4 сая төгрөгийн 158 алдааг залруулж, 74.6 сая төгрөгийн зөрчилд 26 төлбөрийн акт тогтоож, 1,384.1 сая төгрөгийн зөрчилд 72 албан шаардлага, 60.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 79 зөвлөмж өгсөн.

#### Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 10 аж ахуйн нэгж байгууллагаас 4 байгууллага түүвэрт хамрагдаж, 3 байгууллагад зөрчилгүй, 1 байгууллагад хязгаарлалттай / Борхойн баянбүрд ОНӨХХК/, 1 байгууллагад сөрөг / Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ/, 1 байгууллагад татгалзсан /Замын-Үүд НААҮ ОНӨХХК/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 385.6 сая төгрөгийн 49 алдаа, зөрчил илрүүлснээс 296.2 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 16.4 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт, 14.5 сая төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага, 58.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 19 зөвлөмж өгсөн.

#### Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 30 сангийн 29 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 1 сангийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргасан.

Аудитаар нийт 8,095.7 сая төгрөгийн 75 алдаа, зөрчил илрүүлснээс 6,934.9 сая төгрөгийн 45 алдааг залруулж, 63.5 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 1,090.0 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага, 7.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 10 зөвлөмж өгсөн.

#### Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар илэрсэн нийт 15,794.0 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илрүүлж, 15,785.6 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 8.4 сая 1 акт өгсөн.

Аудитаар нийт 15,810.2 сая төгрөгийн 2 алдаа илэрснээс, аудитын явцад 15,810.2 сая төгрөгийн 2 алдааг залруулсан.

Үүнд: Санхүүгийн байдлын тайланд Хамрын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨҮГ-ийн тайлан нэгтгүүлэхдээ бусад хөрөнгө зардалд тавигдах хөрөнгийн дүнг батлан хамгаалах, цэргийн зориулалтай тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл дүн дээр 24.6 сая төгрөгөөр буруу тайлагнаасныг аудитын явцад залруулсан.

Аймгийн ОНХС болон Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дуусаагүй, төсөл арга хэмжээнд тайлант онд олгосон санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр тайлагнасан алдааг залруулж ТЕЗ-ийн тайланд нийт 15,785.6 сая төгрөгийн алдааг залруулав.

Аудитаар нийт 8.4 сая төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 8.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоолоо.

#### **5.1 Төлбөрийн акт**

Тайлант онд Засаг даргын бусад ангилагдаагүй нөөц хөрөнгийн зардлаас ИТХ-аар батлаагүй зардал болох Дорноговь Орон сууц ОНӨААТҮГ-т цалингийн зардалд 8.3 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 68.1." Орон нутгийн тесөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална" гэж заасныг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.